УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| *1* | *2* | *3* | *4* | *5* | *6* |
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах | Салбар нэгж, орон нутагт соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгуулсан байх | Нэгдсэн арга хэмжээ 2 удаа зохион байгуулж, тайлагнасан байна. | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн “ШүгэлҮлээцгээе” “авлигын эсрэг нэгдье” “Авлигыг мэдээлэх 110 тусгай дугаарын сурталчилгаа” “Үгүй гэж хэлээд өөрчилье” аянуудыг байгууллагын албан ёсны цахим хуудасаар шэйр хийн түгээсэн нь 560 үзэлттэй, хэлтсийн 46 албан хаагчид өөрсдийн фэйсбүүк хуудсаар “Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс” гэсэн пайж хуудсанд байршуулсан тухай бүр нь шэйр хийн иргэдийг соён гэгээрүүлэх ажиллагааг түгээн дэлгэрүүлж байна. |
| | | 1.2.Байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан гаргадаг тараах материал, цахим хуудас зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд | Тараах материал хэвлүүлж сурталчилсан байх | Авлигын хор хөнөөлийг иргэдэд сурталчлан таниулж түгээсэн | Хэлтсийн үйлчилгээний заал, нэг, хоёрдугаар давхарт наан иргэдэд харагдахуйц байдлаар авлигын эсрэг мэдээлэх хуудсыг наан байршуулсан.<br>Байгууллагын төсвийн орлого, түүний зарцуулалт, хуваарилалт, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан суртачлах | | байна | гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, хэтрэлт, хэмнэлтийн тайланг сар бүрийн 7-ны өдөр шилэн дансанд байршуулдаг. Мөн байгууллагын /www.Zavkhan. burtgel.gov.mn/ цахим хуудаст 5 удаа шинэчлэн, байршуулан ажиллаж байна. |
| | | 1.3.Байгууллагын албан хаагчдад чиглэсэн авлигын эрсдлээс ангид байх, ёс зүй шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контентийг бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон нийтэд түгээсэн байх. | Соён гэгээрүүлэх 2 контент түгээсэн байна | Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн Reel хийж байгууллагын цахим хуудасд тавихаар бэлтгэл ажлыг хийж байна. |
| 2. | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа | 2.1.Байгууллагын үйл ажиллагаа онцлог байдалд суурилсан сургалтын хэрэгцээг тодорхойлон "Улсын бүртгэлийн үйл ажиллагааг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь " хэлэлцүүлэг АТГ-тай хамтран зохион байгуулах | Албан хаагчдыг хамруулсан хэлэлцүүлэг хамтран зохион байгуулах | Авлигатай тэмцэх газартай хамтран хэлэлцүүлэг 1 удаа зохион байгуулсан байна | 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Завхан аймгийн прокурорын газартай хамтран сургалт хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөж байна. |

БОЛОВСРУУЛСАН: УЛСЫН БҮРТГЭГЧ Э.ЛХАМСҮРЭН

УЛСЫН БҮРТГЭГЧ 31/1-04